

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг
2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн Хөвсгөл
аймагтай холбогдох заалтын биелэлт**

2010.03.29

Зорилт, арга хэмжээ	Биелэлт
1	2
1.1 Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх;	Сумдын төрийн сангийн төлөөлөгч, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын сургалтыг 2009 оны 6 дугаар сарын 8-9 –нд зохион байгуулж, 22 сумын төрийн сангийн төлөөлөгч, төсөвт байгууллагын 12 нягтлан бодогчдыг хамруулав. Сум бүрт нийт сумдын орон нутгийн байгууллагын төсвийн хуваарийг дэлгэрэнгүй хүргүүлж, нээдттэй, ил тод байх боломжийг бүрдүүлж, төрийн сангийн төлөөлөгч нартай хариуцлага, сахилгыг өндөржүүлэх гэрээ хийж ажилласны үр дүнд төсвийн хэтрэлт гараагүй байна. /Б-100%/
1.2 Хүн амын хүнсний зарим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах;	2009 онд 24963 тн үр тариа, 2969 тн төмс, 1179 тн хүнсний ногоо хурааж авсан нь аймгийн хэрэгцээт гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотооддоо хангах боломж бүрдэв. /Б-100%/
1.3 Төсвийн орлого, зарлагын харьцааг зохистой түвшинд байлгаж, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;	Монгол улсын Засгийн газрын 2008 оны 256 дугаар тогтоолын дагуу аймгийн нийтийн ерөнхий үйлчилгээний салбарын 2010-2012 оны хөтөлбөрт суурилсан төсвийн төсөл боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, 2010 оны төсвийг 4938.2 сая төгрөгөөр батлуулсан нь Сангийн яамны хянасан төсвийн зарлагын хязгаараас 661.8 сая төгрөг, 2009 оны батлагдсан төсвөөс 714,6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. 2009 онд аймгийн хэмжээгээр нийтийн ерөнхий үйлчилгээний байгууллага өмнөх оныхоос өрийг 60.7 сая төгрөгөөр буюу 94,7 сая төгрөгөөр бууруулсан байна. /Б-100%/
1.4 Үр ашиггүй зардлыг бууруулах замаар төсвийн алдагдлыг аль болохоор багасгах;	Аймгийн хэмжээнд 23 сум, 1 тосгоныг төрийн сангийн Онлайн сүлжээнд холбож, байгууллагуудын төсвийн зарцуулалтыг өдөр тутам хянаж, төсвийн үргүй зардлыг санхүүжүүлэхийг зогсоосон. /Б-100%/
1.5 Эдийн засаг, нийгмийн салбарт оруулах хөрөнгө оруулалтын арга хэмжээг эдийн засгийн боломжтой уялдуулан хэрэгжүүлэх;	Аймгийн хэмжээгээр 2009 онд 23186.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 17148.8 сая төгрөг нь улсын төсвөөр, 568.7 сая төгрөг нь орон нутгийн төсвийн хөрөнгө байна. Үүнээс: 2009 онд аймгийн 23 сум, 1 тосгон ЦДАШ шугаманд бүрэн

<p>1.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн бааз бий болгох, хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр боловсруулах;</p> <p>2.1 Хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагааг боловсронгуй болгох;</p> <p>2.2 Засгийн газрын худалдан авах ажиллагааг олон нийтэд ил тод болгох хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах бэлтгэлийг хангах, энэ тухай бүх мэдээллийг цахим хуудсаар мэдээлэх ажлыг эрчимжүүлэх;</p>	<p>холбогдсон нь аймаг, сумдын эдийн засаг, нийгмийн салбарын хөгжилд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээ болов.</p> <p>/Б-100%/</p> <p>Хөвсгөл аймгийн хэмжээнд оруулж байга хөрөнгө оруулалт, шийдвэрлэсэн асуудлын жагсаалтыг сум байршлаар нь гаргаж, гүйцэтгэлийн чанарын үнэлгээ хийж, гарсан хөрөнгийн эх үүсвэр, гүйцэтгэгчээр нь гаргаж, мэдээллийн хэрэгслээр сурталчилж, ил тод байдлыг хангуулж байна. Мөн хөрөнгө оруулалтын чанар, үр ашгийг сайжруулахын тулд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар аймгийн Хөрөнгө оруулалтын 2009-2012 оны хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэн 2009 оны 12 дугаар сарын 7 ны өдрийн 109 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж байна. /Б- 100%/</p> <p>Төсвийн болон төрийн өмчийн давхардсан тоогоор 352 байгууллагад аймгийн төрийн Аудитын газар, Мэдээлэл-Аудит ХХК, Улаанбаатар-аудит ХХК-ын аймаг дахь салбар, БББМ ХХК хараат бус аудитын компаниуд ММННБИ-тэй хамтран нийт 38 аж ахуйн нэгжийн 2008 оны жилийн эцсийн тайланг аудиталлаа. Аудитын компаниудад чанарын дотоод аудитыг стандартын дагуу хийж байх зөвлөмж өгч байна. /Б-100%/</p> <p>Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулах үүднээс тендер шалгаруулалтын зар, мэдээллийг цахим хэлбэрээр гаргаж, аймгийн Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт худалдан авах ажиллагааны зөрчлийг арилгах арга замыг тодорхойлон баталж, 2009 оны 12 сараас эхлэн мөрдөж, Тендерийн үнэлгээний хороонд төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөл оролцуулдаг болов. /Б-100%/</p>
<p>3.1 Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн урт хугацааны бага хүүтэй зээлийн тааламжтай нөхцөлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;</p> <p>4.1 Сумын төв болон малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн хангах;</p> <p>5.1 Малын чанарыг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулж, шилмэл үүлдрийн мал, омгийг бүртгэлжүүлж, цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагааг дэмжих;</p>	<p>Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Зоос банкаар дамжуулан 83 аж ахуйн нэгжид 1-3 жилийн хугацаатай, сарын 1 хувийн хүүтэй 806,0 сая төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеинхээс 11,5 дахин өссөн байна. /Б-100%/</p> <p>Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумдын төвийн өрх ЦДАШ-д холбож, Тариалан сумын малчдад 3.5 сая төгрөгийн сэргээгдэх эрчим хүчээр хангав. /Б-100%/</p> <p>Сүүний чиглэлийн үхрийн фермерийн аж ахуй байгуулахаар санаачлага гаргасан Мөрөн сумын иргэн Д.Пүрэвдоржийн төслийг дэмжин ХХАА-н яаманд уламжилж, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 3 сумын 5 иргэн аж ахуйн нэгжид эрчимжсэн аж ахуй байгуулахад</p>

<p>5.2 Махны нийлүүлэлтийг тогтвортой байлгах зорилгоор үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааг дэмжих;</p> <p>5.3 “Атрын 3 дахь аян”-ы хэрэгжилтийг эрчимжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дотоодын үйлдвэрлэлийн улаанбуудай, төмс, хүнсний ногооны хангамжийг дээшлүүлэх;</p> <p>5.4 Иргэдийн оролцоотойгоор хөв, цөөрөм байгуулах, гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжиж, билчээрийн худаг, уст цэгт шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлэх;</p> <p>5.5 Билчээр, тариалангийн талбайн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлыг зохион байгуулах;</p> <p>5.6 Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийх, усалгаатай газар тариаланг өргөжүүлэх;</p> <p>8.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд Хөвсгөл нуурт усан замын тээврийн хэрэгсэл зорчих чиглэл, маршрутыг тогтоож, тэмдэгжүүлэх, тээврийн хэрэгслийн тусгай зогсоол барих;</p>	<p>эргэлтийн хөрөнгө болон мал, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж, 81,0 сая төгрөгийн зээл олгов. 2009 онд нийт 511,5 мянган толгой малыг үзлэг ангилалтанд хамруулж, үүнээс 35.6 мянган толгой бод мал хамрагдсанаас хээлтэгч 0,9 мянган толгой, хээлтүүлэгч 11,4 мянган толгой, цөм сүргийн 56,2 мянган хээлтүүлэгчийг бүртгэлд авсан байна. /Б- 100%/</p> <p>Хөвсгөл аймагт “Мах маркет үйлдвэр 2009 онд 6200 үхэр, адууны 900 тн мах бэлтгэж, малыг экспортлох 3 аж ахуйн нэгжид эрх олгуулах саналыг холбогдох дээд байгууллагуудад тавьсан байна. /Б-100%/</p> <p>Атрын III аяны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлснээр дотоодын үйлдвэрлэлийн улаанбуудай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл өмнөх жилийнхээс 37,2 хувиар нэмэгдэж, аймгийн хэрэгцээт гурилыг 100, төмс-46,0, хүнсний ногооны-12,8 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангахаар байна. /Б-100%/</p> <p>Хөвсгөл аймгийн хэмжээнд 2009 онд инженерийн болон энгийн хийцтэй худаг 11 суманд 17-г гаргахад-245.2 сая, гар худаг 2-ыг гаргахад-5.6 сая, 10 сумын 14 худаг засварлахад- 39,7 сая, Бүрэнтогтох сумын Загзуугийн аманд хөв байгуулахад- 49,9 сая төгрөг тус тус зарцуулав. /Б-100%/</p> <p>Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Цэцэрлэг, Цагаан-уул, Жаргалт сумдын 20000 га талбайд үлийн цагаан оготно устгахад- 32,0 сая төгрөг зарцуулав. /Б-100%/</p> <p>Усалгаатай талбайн хэмжээг өргөжүүлэх зорилгоор Тээлийн амны 95 га-ийн услалтын системийг сэргээн засварлах урт хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр улсын төсвөөс 106,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг Хөвсгөл Оюут ган ХХК гүйцэтгэж байна. Техникийн шинэчлэлт хийхээр 2009 онд 7 аж ахуйн нэгж 8 трактор, 3 аж ахуйн нэгж тус бүр нэг комбайн өөрсдийн хөрөнгөөр урт хугацаатай зээлэнд хамрагдан авч техникийн парк шинэчлэлт хийсэн байна. /Б-100%/</p> <p>Ажил хийгдээгүй. /Б-0/</p>
<p>9.1 Айл өрх бүрийг интернетийн хэрэглэгч болгох, малчдыг гар утас ашиглах</p>	<p>Аймгийн хэмжээний 23 сум, 1 тосгон, Арбулаг сумын Сүмбэр баг, Рашаант сумын Улаан-Од, Тариалан сумын Тавантолгой багуудын ЦДАШ-</p>

<p>нөхцөлийг бүрдүүлэх, шилэн кабельд холбогдсон сумдад электрон шуудангийн үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах;</p>	<p>нд, Бүрэнтогтох сумын Бүрэнхаан багийн төвд нарны цахилгааны эх үүсвэр суурилуулж, тухайн багийн малчдыг гар утас барих, интернет ашиглах боломж бүрдүүлэв. /Б-100%/</p>
<p>ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, БУС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</p>	
<p>10.1 Мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн ой бүхий талбайг эзэмшүүлэх үндсэн дээр ойг нөхөн сэргээж, хамгаалах менежментийг бүрдүүлэх;</p>	<p>Аймгийн Засаг даргын 2009 оны 169 дүгээр захирамжаар ойн алба болон сум дундын ойн ангийг зургаан хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Аймгийн хэмжээд нийт ойжуулалт, мод үржүүлгийн чиглэлээр эрх авсан 18 байгууллага, ойд арчилгаа цэвэрлэгээний огтлолт явуулах чиглэлээр 2 байгууллага, 327 га-д ойжуулалт, 100 га-д байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийж, амьдралт 75,1-100 хувьтай байна. 2009 онд 43 нөхөрлөлийн 931 хүн 145.3 мянган га газрыг гэрээгээр эзэмшин хамгаалаж, зүй зохистой ашиглахаар сум дын иргэдийн төлөөлөгчдын хурлын шийдвэр гарсан. Нөхөрлөлүүдийн ой зохион байгуулалтын материал нь боловсрогдож, 12 нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөг Дэлгэрмөрөн сум дундын ойн анги хийж гүйцэтгэж, 21 нөхөрлөлийн 125,8 мянган га талбай бүхий ойд улсын төсвийн хөрөнгөөр ой зохион байгуулалт хийж өгөв. /Б-100%/</p>
<p>10.2 Ойжуулалт, мод үржүүлгийн ажлын чанарыг дээшлүүлэх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;</p> <p>Идэвхитэй үйл ажиллагаа явуулах нөхөрлөлийн тоо</p>	<p>Хөвсгөл аймагт НҮБ-ын хамтын оролцооны ойн менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл Түнэл сумын 2 ойн нөхөрлөл, Цагаан-үүр сумын 1 ойн нөхөрлөлийг загвар нөхөрлөл болгохоор сонгон хамтран ажиллаж байна. 2009 оны 9 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 06-ныг хүртэл БЛАЖГ-ын мэргэжилтнүүд, сумдын БОХ-ын байцаагч, байгаль хамгаалагчдад хамтын эзэмшлийн ойн менежментийн сургалт явуулав. Б-100%/</p>
<p>10.3 Биологийн төрөл зүйлийг хамгаалах, ТХГН-ийн менежментийг бэхжүүлэх, аялал жуулчлал хөгжүүлэх үйл ажиллагаанд ард иргэдийг өргөн оролцуулсан хамтын менежментийг боловсронгуй болгох;</p>	<p>Аймгийн нийт газар нутгийн 50 дугаар өргөрөгөөс хойших газар нутгийг улсын тусгай хамгаалалтад орсноос бусад бүх газар нутгийг байгалийн иж бүрдлийн нөөц газрын ангилалаар аймгийн хамгаалалтад авч хамгаалалтын тусгай горимыг тогтоосноор дээрх газар нутагт ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ан амьтан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг, байгалийн ургамал ашиглах асуудлыг нарийн зохицуулалтаар шийдвэрлэх болов. Алтай соёны төслийн нэгжээс Улаан-уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур сумд, Хатгал тосгоны байгаль хамгаалагч нарт мотоцикль, нормын хувцас, иргэдийн нөхөрлөлийн гишүүд, байгаль хамаалагчид, улсын байцаагч нарыг чадавхижуулах, Тэнгис Шишгэдийн сав газар, Жар Харууны нурууг улсын тусгай хамгаалалтанд оруулах, Улаан тайга, Хөвсгөлийн</p>

	байгалийн цогцолборт газрын хилийн заагийг өргөтгөх асуудлаар төсөл боловсруулах ажил зохион байгуулсан байна. /Б-100%/
Зорилт 11. Агаар, ус, хөрсний бохирдол, орчны доройтлыг бууруулах, хянах тогтолцоог боловсронгуй болгоно.	Аймгийн УЦУОШТөв агаарын хамгийн их бохирдолттой Мөрөн сумын төв захын ойролцоо Магнай трейд шатахуун түгээх станц дээр Агаарын харуулын алба шинээр байгуулан ажиллуулж эхлэв. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2009 оны 72 дугаар тогтоолоор Сэлэнгэ, Дэлгэрмөрөн, Шишгэд, Идэр, Эг, Үүр, Тэс зэрэг голуудын сав газруудын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталснаар усны менежментэд нутгийн иргэдийн оролцоог сайжруулах ажлыг зохион байгуулалтад оруулах боломжтой болов. Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашиглагдаж буй бүх сумдын уст цэг, гол мөрний хамгаалалтын бүсийг сумдын Засаг даргын захирамжаар тогтоолоо. /Б-100%/
11.1 Алтны шороон болон бага нөөцтэй орд газар ашиглахыг, мөн ойн сав, усны хагалбар газарт буюу байгаль орчинд халтай технологи хэрэглэж ашигт малтмал олборлохыг хориглох;	Улаан-Уул сумын Хөгийн голын алт олборлохыг зогсоох талаар аймгийн Засаг даргын захирамж гарган, аймгийн МХГ, Цагдаагийн хэлтэсээс ажлын групп гарган 2 удаа ажиллуулсан боловч бүрэн буулгаж бадаагүй байна. /Б-30%/
13.1 Хүн амын өсөлтийг дэмжих хүрээнд Хүүхдийн мөнгө, гэр бүл, шинэ хүүхэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;	2009 онд 38756 хүүхдэд 1162.7 сая, 798 шинэ гэр бүлд 399,0, 2235 шинэ төрсөн хүүхдэд 223,5 сая, Монгол улсыг хөгжүүлэх сангаас олгож буй хүүхэд хөгжлийн мөнгөн тэтгэмжид 42760 иргэнд 3207,0 сая төгрөг зарцуулаад байна. /Б-100%/
13.2 Ажлын байр шинээр бий болгох замаар хүн амын ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх;	2009 онд 585 иргэнийг ажилд зуучилж, 306 ажлын байрыг шинээр бий болгосон. /Б-70%/
13.3 МХЗ-уудын шалгуур үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих мэдээллийн төрөлжсөн болон тусгай санг улс, аймаг, нийслэлийн түвшинд холбогдох мэдээллээр бүрдүүлэх;	Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэглээний үнэлгээг нэг бүрчлэн гаргаж, мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, зорилтуудын хэрэгжилтэнд хяналт тавих мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор “Мэдээ, тайлангийн үнэн бодит байдлыг хангах арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 2009 оны 172 дугаар захирамж гарган аймгийн хэмжээнд мөрдүүлж, хэрэгжилтийг бүх суманд шалгаж, дүнг аймгийн Засаг даргын өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэв. /Б-100%/
14.1 Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх;	Аймгийн хэмжээгээр Үдийн цай хөтөлбөрт 35 сургуулийн 454 бүлгийн 13738 хүүхдийг хамруулж, 2009 онд 772.6 сая төгрөг зарцуулав. /Б-100%/
14.2 Ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх;	ЕБС-ийн сургалтын 12 жилийн тогтолцоонд 35 сургуулийг хамруулав. /Б-100%/
14.3 Хөдөөгийн сургуулийн дотуур	Хөвсгөл аймаг суманд 200 ортой дотуур байр

<p>байрны хангамжийг нэмэгдүүлэх;</p>	<p>ашиглалтанд оруулж, Бүрэнтогтох, Ренчинлхүмбэ, Цэцэрлэг, Шинэ-Идэр сумдын ЕБС-ийн дотуур байрыг засварлаж, Алаг-Эрдэнэ сумын ЕБС-ийн дотуур байрыг барьж байна. /Б-100%/</p>
<p>14.4 “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх,</p>	<p>Хүүхэдэд бүрт компьютер хөтөлбөрийн хүрээнд Алаг-Эрдэнэ сумын ЕБС-д-184, Ханх сумын ЕБС-д-205, Хатгал тосгоны ЕБС-д 243 ш нэг бүр нь 224,5 мянган төгрөгийн нийт 632 ш компьютер олгоход 141,9 сая төгрөг зарцуулаад байна. /Б-100%/</p>
<p>14.5 Ерөнхий боловсролын сургуулийг интернетэд холбох ажлыг эрчимжүүлэх;</p>	<p>2009 онд Жаргалант, Тосонцэнгэл, Чандмань-Өндөр сумдын ЕБС-ийг интернет холбов. /Б-100%/</p>
<p>14.6 Дотоодын их, дээд сургуульд суралцахаар зохих журмын дагуу элсэж, хөдөөгийн сумын ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг даргын захиалгаар албан ёсны гэрээ байгуулсан оюутны сургалтын зардлыг төрөөс хариуцах механизм бий болгож, 2009-2010 оны хичээлийн жилээс мөрдөх;</p>	<p>Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумын захиалгаар төрийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлж, 2 оюутныг ЭМШУИС-д 2009-2010 онд суралцуулж эхлээд байна. /Б-100%/</p>
<p>14.7 Сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж тогтмолжуулах, соёлын төвүүдийн барилгыг шинэчилж, засварлах, хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах замаар хүүхэд, залуус, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэх;</p>	<p>Тариалагн, Цагааннуур, Цэцэрлэг сумдын соёлын төвийн барилгыг засварлахад-14,7, 8 сумын соёлын төвийн техник хэрэгсэл, материаллаг баазыг бэхжүүлж, 11 сумын 15 багийн соёлын төв, мэдээлийн төвийг засварлаж, тохижуулж үйлчилгээг тогтмолжуулав. /Б-100%/</p>
<p>15.1 Малчин, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг нөхөн үржихүйн эм, хэрэгслээр тогтвортой хангах ажлыг үе шаттайгаар эхлүүлэх;</p>	<p>Цаатан иргэдийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2009 оны 6 дугаар сарын 8-наас 18-ны өдрүүдэд эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эмч, ЭХО, лабораторийн шинжилгээгээр явуулын үйлчилгээг цаатан иргэдэд үзүүлсэн. 0-16 насны 103 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад 54,3 хувьд нь ямар нэг эмгэг илэрсэн байна. 17 эцэг, эхэд тусламж хайх мэдлэг олгох сургалт явуулж, БЗДХ-ыг илрүүлэх үзлэгт 177 хүнийг хамруулж, үнэ төлбөргүй эмчилсэн байна. Аймгийн хэмжээнд жирэмсэлтээс хамгаалах эм хэрэгслэлийг 2 удаа татан авалт хийж, нийт 34.0 сая төгрөгийн 3 төрлийн хамгаалах эм, хэрэгсэл ба төрөхийн нэн шаардлагатай 7 нэр төрлийн эм хүлээн авч хөдөөгийн малчин, эмзэг бүлгийн иргэдэд 3 удаа хуваарилалт хийж, эмзэг болон хөгжлийн бжрхшээлтэй 5570 иргэнд 12973.2 мянган төгрөгийн эм хэрэгслэлийг үнэгүй олгосон байна. /Б-100%/</p>
<p>18.1 Экологийн сүйрлээс сэрэмжлэн хамгаалах, ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг ажил үүрэг</p>	<p>Ойн түймрээс урьдчилан сэргийлэх болон түймрийн голомтыг арилгахад бүх сумын дүйцүүлэх албаны 116 хүнийг тогтмол хамруулж байна. /Б-70%/</p>

<p>биелүүлэхэд цэргийн дүйцүүлэх албаны оролцоог нэмэгдүүлэх;</p> <p>19.1 Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, цахим сүлжээнд суурилсан Нэг цэгийн үйлчилгээг бий болгох;</p>	<p>Мэргэжлийн хяналтын газрыг дотоод сүлжээнд оруулж, ил тод, нээлттэй байдлыг хангахын тулд төрийн байгууллага болон бизнес эрхлэгчдийн дунд 500 хүнийг хамруулан мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарын мэдлэг ур чадвар, ёс зүйн хяналтын үр дүнгийн талаар санал асуулга явуулж, байцаагч нарын ажил дүгнэх гол шалгуур үзүүлэлт болгож, Угтаж үйлчлэх цэг нээж 4 байцаагч ажиллуулан иргэдийн хүлээж авч, санал хүсэлтийг барагдуулж байна . /Б-70%/</p>
--	--

Аймгийн дүн

92,8

Хянасан:

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Х.Ган-Очир

Хэрэгжилтийг тооцсон:

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Лхагва